

**Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт (Эм Эр Аи аппарат)
болон Глобаль сангийн дэмжлэгтэй хэрэгжиж буй
төслүүдийн үйл ажиллагаа**



**Бэлтгэгдсэн
тоног төхөөрөмж бүрэн
ашиглагдахгүй байна**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:

ҮАГ-ын хоёрдугаар газар

Захирал	О.Мэндбаяр
Аудитын менежер	Х.Баярмаа
Ахлах аудитор	Ц.Сугармаа
Аудитор	З.Цээнээ
Шинжээч	Л.Эрдэнэчулуун
	Ш.Отгонбаяр
	Д.Болормаа

2007 оны 6 дугаар сар

Тайланг ҮАГ-ын вэб сайтаас үзнэ үү:

www.mnao.pmis.gov.mn

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах асууж лавлах
зүйл байвал 261805 дугаарын
утас, 323266 дугаарын
факсаар харилцана уу.

ХАЯГ. Үндэсний аудитын газар.
Засгийн газрын 4 дүгээр байр.
Бага тойруу-6
Улаанбаатар-46
Монгол Улс

Ерөнхий зүйл

Товчилсон үгийн тайлбар.....	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....	3

Бүлэг 1

Бэлтгэгдсэн тоног төхөөрөмж бүрэн ашиглагдахгүй байна

Батлагдсан дүнд багтаан зохицуулалт хийгээгүй байна.....	4
---	---

Хөрөнгө оруулалт төлөвлөгөөний дагуу хийгдэхгүй байна.....	5
---	---

Сонгон шалгаруулалтад тендерийн хуулийг мөрдөөгүй байна.....	6
---	---

Бэлтгэгдсэн тоног төхөөрөмж бүрэн ашиглагдахгүй байна.....	8
---	---

Их засвар, тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаагүй байна.....	8
--	---

Засварын ажил хийгдээгүй байна.....	9
-------------------------------------	---

Зөвлөмж.....	9
---------------------	----------

Бүлэг 2

Төслүүдийн нягтлан бодох бүртгэлийг сайжруулах шаардлагатай байна

ОНЗЗ төслүүдийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх үүргээ бүрэн биелүүлээгүй байна.....	10
---	----

Төслийн 2006 оны үйл ажиллагаа саатжээ.....	11
---	----

Бүртгэлийн бодлого боловсруулах шаардлагатай байна.....	12
--	----

Зөвлөмж.....	13
---------------------	-----------

Холбогдох байгууллагын санал

Эрүүл мэндийн яамны санал.....	14
Хөтөлбөр зохицуулах нэгжийн санал.....	15

Хавсралт

Хавсралт №1,2.....	19
--------------------	----

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
СЯ	Сангийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ТБУСТ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
ТБОНӨХБАУХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
МСТН	Монголын сүрьеэтэй тэмцэх нийгэмлэг
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирус
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
ДОТС	Шууд хяналттай богино хугацааны эмчилгээ
ОНЗЗ	Орон нутгийн зохицуулах зөвлөл
ХЗН	Хөтөлбөр зохицуулах нэгж
ХСҮТ	Хавдар судлалын үндэсний төв
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
НББ	Нягтлан бодох бүртгэл
ТББ	Төрийн бус байгууллага

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

УИХ-ын санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, Глобаль сангийн дэмжлэгтэй хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудит хийв.

Дараахь асуудлыг шалгаж дүгнэлт, зөвлөмж гарган холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд:

- Улсын төсвөөс 2006 онд эрүүл мэндийн салбарт олгосон хөрөнгө оруулалт, түүний дотор Эм Эр Аи аппаратын худалдан авалт үр дүнтэй хийгдсэн эсэх
- Глобаль сангийн дэмжлэгтэй хэрэгжиж буй төслүүдийн 2003-2006 оны үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэн эсэх

Аудитын явцад асуудлыг шинжлэх, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тайлбар мэдээ гаргуулах, санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглав.

Аудитад ашигласан шалгуур, стандартын талаархи мэдэгдэл

Аудитад дараахь хууль эрхийн акт, баримт бичгийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- “Улсын төсвийн хөрөнгөөр 2006 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт батлах тухай” ЗГ-ын 2006 оны 19 дүгээр тогтоол
- ЭМЯ болон Глобаль сангийн хооронд байгуулсан тусламжийн гэрээнүүд, төслийн баримт бичиг
- Холбогдох бусад хууль, эрхийн актууд.

Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн шалгалтын журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан гүйцэтгэлийн аудитын төлөвлөгөөний дагуу аудитыг гүйцэтгэж холбогдох баримт материалыг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

Бэлтгэгдсэн тоног төхөөрөмж бүрэн ашиглагдахгүй байна

1.1 Эрүүл мэндийн салбарын 2000-2005 оны хөрөнгө оруулалтын нийт зардлын 83 хувийг барилга, их засварт, үлдэх хэсгийг автомашин тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан байна.

1.2 Засгийн газрын 2006 оны 19 дүгээр тогтоолоор “Улсын төсвийн хөрөнгөөр 2006 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг, Сангийн сайдын 2006 оны 93 дугаар тушаалаар “2006 онд хэрэгжүүлэх их засварын ажлын жагсаалт”-ыг тус тус баталжээ.

1.3 2006 онд салбарын хөрөнгө оруулалтад нийт 6460,0 сая төгрөг батлагдсанаас 2800,0 сая төгрөгийн автомашин, тоног төхөөрөмж бэлтгэхээр төлөвлөжээ.


1.4 Барилга, их засварыг ЭМС-ын 2002 оны тушаалаар баталсан 2005 он хүртэл хэрэгжүүлэх ажлын жагсаалт, автомашины хэрэгцээг харьяа байгууллагуудын жил бүрийн үйл ажиллагааны тайлан, тоног төхөөрөмжийг худалдан авах шаардлагатай хөрөнгийн тооцоонд тус тус үндэслэн төлөвлөсөн байна.

Батлагдсан дүнд багтаан зохицуулалт хийгээгүй байна

1.5 Эрүүл мэндийн салбарын мастер (2006-2015) төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын талаар тодорхой асуудлууд тусгагдаагүй байна.

1.6 Засгийн газрын 2006 оны 19 дүгээр тогтоолын 3-т “төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэлийн явц, ашиглалтад оруулах хугацаа, тэргүүлэх ач холбогдлыг харгалзан шаардлагатай гэж үзвэл төсвийн ерөнхийлөн захирагчдын саналыг үндэслэн энэ тогтоолоор батлагдсан дүнд багтаан зохицуулалт хийж ажиллах ...” гэж заасныг үндэслэн Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2006 оны 308/319 болон 380/367 дугаар тушаалаар 2006 оны төсвийн хөрөнгө оруулалтад зохицуулалт хийжээ.

Салбарын хөрөнгө оруулалт /сая.төг/



Зохицуулалт хийсэн байдал

(сая төгрөгөөр)

Хөрөнгө оруулалтын ангилал	Батлагдсан	Хэмнэлт	Хэмнэлтээс нэмсэн	Зохицуулалт Нэмэгдсэн	Зохицуулалт Хасагдсан	Зохицуулсан төлөвлөгөө
Шилжих барилга	2350.0	67,8		50,0	149,8	2182,4
Шинэ барилга	560.0	0		10.0	10.0	560,0

Тоног төхөөрөмж	2800.0	18,7	37,9	139,8	100.0	2859,0
Их засвар	750.0	10.0	58,6	99,0	39	858,6
Дүн	6460.0	96,5	96,5	298,8	298,8	6460,0

1.7 Шилжих болон шинээр эхлэх барилга, тоног төхөөрөмж, их засварын санхүүжилтээс гарсан 96,5 сая төгрөгийн хэмнэлт, шилжих барилгын ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан санхүүжилтийг нь хойшлуулсан 149,8 сая төгрөг, Эм Эр Аи аппаратын төлбөл зохих гэрээний үнийн дүнгээс 100,0 сая төгрөгийг дараа онд төлөхөөр шилжүүлсэн зэрэг нийт 395,3 сая төгрөгийн зохицуулалт хийсэн байна.

1.8 Эм Эр Аи аппарат худалдан авахад төлөвлөсөн 1158,3 сая төгрөгөөс 100,0 сая төгрөгийг 2007 оны төсөвт тусгуулахаар хойшлуулсан нь энэ хэмжээгээр төсөвт өртгийг хэтрүүлсэн гэж үзэхээр байна.

Хөрөнгө оруулалт төлөвлөгөөний дагуу хийгдэхгүй байна

1.9 Эрүүл мэндийн салбарын 2006 оны хөрөнгө оруулалтад СЯ 6454.0 сая төгрөг санхүүжүүлсэн боловч ЭМЯ гүйцэтгэгчид санхүүжилтийн 89.0 хувийг ондоо багтаан шилжүүлсэн байна.

Ангилал	Төсөвт өртөг	2006 оны		Зөрүү /+:-/
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Шилжих барилга	4.569,0	2,350.0	2,181.3	(168.7)
Шинээр эхлэх	2.240,0	560.0	550.1	9.9
Их засвар	750,0	750.0	858.3	108.3
Тоног/төхөөрөмж	2.800,0	2,800.0	2,143.2	(656.8)
Нийт	10.359,0	6.460.0	5.732.9	(727.1)

1.10 Эрүүл мэндийн дэд сайд, ЭМЯ-ны техникийн комиссын дарга Ш.Энхбатаар ахлуулсан ажлын хэсэг 2006 онд хөрөнгө оруулалтаар худалдан авах шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалтыг гаргажээ. Үүнд 2800,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай гэж тооцож, төсвийн хүрээний мэдэгдэлд тусган УИХ-аар батлуулжээ. (Хавсралт № 1)

1.11 Төсвийн хүрээний мэдэгдэлд:

- Монгол Улсад хавдрын эрт үеийн оношлогоог сайн хийж чадахгүй байгаа нь ашиглаж байгаа тоног төхөөрөмжтэй холбоотой, ХСҮТ-д ашиглагдаж байгаа туяа эмчилгээний аппаратууд олон жил ашиглагдаж хуучирснаас техникийн болон цацрагийн шаардлагыг хангахгүй болсон,
- 2004 онд зайн шарлагын аппаратын зарим иж бүрдлийг Монгол Улсын Засгийн газар, Олон улсын атомын энергийн агентлагийн санхүүжилтээр худалдан авсан боловч энэхүү аппаратын гол хэсэг болох төлөвлөлтийн симулятор аппарат шинэчлэгдээгүй тул өмнө хэрэглэж байсан аппаратыг ашиглаж байна. Үүний үйл ажиллагаа нь доголдож хавдрын туяа шарлагын тусламж үйлчилгээ зогсоход хүрээд байна гэж танилцуулж байжээ.

1.12 Гэтэл ЭМ-ийн сайд асан Л.Гүндалай хавдрын төлөвлөлтийн симулятор аппарат худалдан авах төлөвлөгөөг Эхо аппарат авах төсөл болгон өөрчилсөн байна.

1.13 Төлөвлөлтийн симулятор аппарат доголдож саатах болсноор туяа эмчилгээний төлөвлөлт удааширч, эмч ажилтны гараар хийх механик ажиллагаа нэмэгдсэн, хавдар өвчний эмчилгээний төлөвлөлтийг нарийвчлан гаргаж чадахгүй болсноос өвчтөн аппаратанд хугацаандаа орж чадахгүй хүлээгдэл үүссэн байна.

1.14 Төлөвлөлтийн симулятор аппаратын худалдан авах үнийг хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд 615.0 сая төгрөгөөр төлөвлөж байсан боловч 250 ширхэг зөөврийн Эхо авснаар төлөвлөсөн хэмжээнээс 613,0 сая төгрөгийн нэмэлт зардал гаргаж, 2006 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан нэн түрүүнд авах шаардлагатай 11 төрлийн аппарат авах боломжийг алджээ.

1.15 Сумын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5082:2001 стандартын 4 дүгээр зүйлд зөвхөн нэгдүгээр зэрэглэлийн суманд эхо аппарат ашиглахаар заасан. ЭМЯ-ны гаргасан судалгаагаар нийт 316 сумаас зөвхөн 73 сумын эмнэлэг нэгдүгээр зэрэглэлд хамаардаг бөгөөд эдгээрээс 2006 оны байдлаар 22 сумын эмнэлэг эхо аппаратгүй байжээ.

1.16 Гэтэл 109 сумын эмнэлэгт тус бүр нэг эхо аппарат олгож 87 сумын эмнэлэгт стандартад нийцээгүй хөрөнгө оруулалт хийжээ. Эдгээр сумдын эмнэлэгт эхо оношлогоо хийх мэргэжилтнийг дөнгөж энэ оноос бэлтгэж эхлээд байна. 2007 оны 5 дугаар сарын 5-ны байдлаар 105 эхо аппарат хуваарилагдаагүй үлдэгдэлтэй байв. (Хавсралт №2) Дээрх байдлаас үзэхэд 2006 онд 943,4 сая төгрөгийн хэрэгцээгүй худалдан авалт хийсэн байна.

1.17 Хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж бэлтгэхдээ салбарын хэмжээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдээс эрүүл мэндийн байгууллагуудад нийлүүлсэн эмнэлгийн техник хэрэгслийн хангамжтай уялдуулаагүйгээс үр ашиггүй хуваарилалт хийсэн байна. Тухайлбал, ЭМС-ын тушаалаар Увс аймгийн Өмнөговь суманд зөөврийн эхо аппарат хуваарилсан боловч тус сумын эмнэлэг “Тогтвортой амьжиргаа” төслөөс эхо аппарат өмнө нь авсан байжээ.

Сонгон шалгаруулалтад тендерийн хуулийг мөрдөөгүй байна

1.18 ЭМЯ Улсын төсвийн хөрөнгөөр 2006 онд суурин Эм Эр Аи, зөөврийн Эхо аппарат худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгох “нээлттэй” тендер зарлахдаа хоёр бус нэг багц болгон зарлаж, худалдан авах ажиллагааны илүү үр ашигтай өрсөлдөөнийг дэмжих зарчмыг алдагдуулсан байна.

1.19 Үнэлгээний хороо тендерийн санал ирүүлсэн компаниудаас Мэдика Монголиа, Булгат овоо ХХК-иудын түншлэлийг шалгаруулсан боловч компаниудын борлуулалтын орлогын дундаж дүнгийн нийлбэр үнийн дүнгийн 25 хувьд хүрэхгүй байсан нь санхүүгийн шалгуур үзүүлэлтүүдийг бүрэн хангахгүй байна гэж СЯ-ны Худалдан авах ажиллагааны газар үзээд ЭТТ 06-2006 тендерийг хүчингүй болгосон байна.

1.20 ЭМС 2006 оны 7 дугаар сарын 25-ны өдөр суурин Эм Эр Аи, зөөврийн Эхо аппарат худалдан авах ажиллагааны ерөнхий менежерээр Улсын клиникийн төв эмнэлгийн захирал Н.Оюунцэцэгийг томилох тухай 248 дугаар тушаалыг ТБУСТ хуулийн 12.2 дугаар зүйл, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 45.5 дугаар заалтуудыг үндэслэн гаргаж, Улсын клиникийн эмнэлгийг захиалагчаар томилсон нь эрх зүйн чадамжийн хувьд учир дутагдалтай байна.*

* ТБУС-ийн тухай хууль

➤ 12.2 “Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 12.1-т заасан зарим эрхээ ерөнхий менежерт бичгээр шилжүүлж болох.”


ТБОНӨХБАҮХА тухай хууль

➤ 45.4 “Тодорхой нэр төрлийн бараа, ажил, үйлчилгээг нэгдсэн журмаар худалдан авах нь хэмнэлттэй бөгөөд үр ашигтай бол хоёр болон түүнээс дээш захиалагч, худалдан авах ажиллагааг төвлөрүүлэн, эсхүл хамтран зохион байгуулж болно”

45.5 “Худалдан авах ажиллагааг энэ хуулийн 45.4-т зааснаар төвлөрүүлэн зохион байгуулах шийдвэрийг төсвийн ерөнхийлөн захирагч гаргаж, захиалагчийг томилно”

1.21 Захиалагч суурин Эм Эр Аи, зөөврийн Эхо аппарат худалдан авах ЭТТ 08-2006 “хязгаарлагдмал” тендерийг 2006 оны 8 дугаар сарын 13-ны өдрөөс 15 хоногийн хугацаатайгаар нээлттэй тендерт оролцож ерөнхий үзүүлэлтээрээ тэнцсэн компаниудын дунд дахин зарлажээ.

1.22 Хязгаарлалттай тендерт, Булгат овоо ХХК, Женерал Электрик үйлдвэрийн түншлэлийг сонгон шалгаруулсан боловч Монолаб ХХК Нийслэлийн захиргааны хэргийн шүүхэд тендерийг хүчингүй болгох хүсэлт гаргасан байна.



1.23 Нийслэлийн захиргааны хэргийн шүүгчийн 2006 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 140 дүгээр захирамжаар Монолаб ХХК болон хариуцагч ЭМЯ-ны тендерийн үнэлгээний хороо эвлэрснийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

1.24 Тендерийн үнэлгээний хороо хуралдаж, “Шүүхийн явцад нэхэмжлэгч, хариуцагч талууд зөвшилцсөн болон Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн шаардлагыг үндэслэн ЭТТ 08-2006 тендерийг хүчингүй болгож байна” гээд ТБОНӨХБАУХА тухай хуулийн 34.1.1 дүгээр заалтыг үндэслэн өмнө нь ЭТТ 06-2006, ЭТТ 08-2006 тендерт оролцож байсан Монолаб ХХК, Булгат овоо ХХК-тай шууд гэрээ байгуулах шийдвэр гаргажээ.

Дээрх үйл явцыг цаг хугацааны хувьд авч үзвэл:

	Шийдвэр гаргасан он, сар, өдөр
Нийслэлийн захиргааны хэргийн шүүгчийн захирамж гарсан	2006 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр
ЭТТ 08-2006 тендерийн үнэлгээний хорооны дүгнэлт гарсан	2006 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр
Гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдлийг хүргүүлсэн	2006 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр
Сангийн яамнаас хязгаарлагдмал тендер зарлахыг зөвшөөрсөн албан бичиг ирүүлсэн	2006 оны 9 дүгээр сарын 29-ны өдөр

1.25 Нийслэлийн захиргааны хэргийн шүүгчийн захирамж болон үнэлгээний хорооны дүгнэлт, гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдэл нэг өдөр гарсан нь тендер шалгаруулалтад хуйвалдаан орсон байж болзошгүй гэж харагдахаар байна. Ингэхдээ ТБОНӨХБАУХА тухай хуулийн 53.1-д заасны дагуу СЯ-аас зөвшөөрөл авалгүйгээр тендер зарлаад гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдлийг хүргүүлсний дараа 9 дүгээр сарын 29-нд нөхөн авчээ. Суурин Эм Эр Аи, зөөврийн Эхо аппарат худалдан авах үйл ажиллагаанд ТБОНӨХБАУХА тухай хуулийг зөрчиж, шууд гэрээ байгуулсан байна.

1.26 Монолаб ХХК Эм Эр Аи аппаратыг татварын зардлаа оролцуулан 899,0 мянган ам.доллар буюу 1066,2 сая төгрөгөөр нийлүүлэх үнийн санал ирүүлсэн байхад 1158,3 сая төгрөгөөр, Булгат овоо ХХК зөөврийн эхо аппаратыг татварын зардлаа оролцуулан 990,0 мянган ам.доллар буюу 1156,3 сая төгрөгөөр нийлүүлэх үнийн санал ирүүлсэн байхад 1228,5 сая төгрөгөөр тус тус гэрээ байгуулж ирүүлсэн саналаас нийт 164,3 сая төгрөгөөр илүү үнээр нийлүүлэх гэрээ байгуулсан байна. Уг гэрээг СЯ-ны Төсвийн бодлого зохицуулалтын газрын Хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга О.Бат-Эрдэнэ, мэргэжилтэн Н.Сансармаа нар хянаж, ЭМЯ-ны Санхүү эдийн засгийн газрын мэргэжилтнээр ажиллаж байсан Б.Зоригт, эмнэлгийн тоног төхөөрөмж хариуцсан мэргэжилтэн П.Отгонжаргал,

Улсын клиникийн төв эмнэлгийн санхүүгийн албаны дарга Д.Цэндсүрэн нар захиалагчийг төлөөлөн гарын үсэг зурж, санхүүжилт олгожээ.

1.27 Булгат овоо ХХК 250 ширхэг зөөврийн Эхо аппаратыг 2006 оны 12 дугаар сарын 5-ны дотор, Монолаб ХХК суурин Эм Эр Аи аппаратыг 2006 оны 12 дугаар сарын 20-ны дотор нийлүүлэх үүрэг хүлээж, ЭМЯ-тай гэрээ байгуулжээ. Гэвч Эхо аппаратыг 2006 оны 12 дугаар сарын 20-нд, Эм Эр Аи аппаратыг 2007 оны 2 дугаар сарын 22-нд хүлээлгэн өгч гэрээний хугацааг 15-62 хоногоор хэтрүүлж, гэрээний үүргээ биелүүлээгүй байхад ЭМЯ хариуцлага тооцоогүй байна.

1.28 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Булгат овоо ХХК 2006 онд нийт 1338,3 сая төгрөгийн , Монолаб ХХК 1158,3 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлж, борлуулалт хийсэн боловч Булгат овоо ХХК 70,0 мянган төгрөгийн, Монолаб ХХК 2700,0 мянган төгрөгийн албан татвар төлсөн байна. Иймд татвар ногдох орлогоо бүрэн тооцож төлсөн эсэхийг татварын байгууллагаар шалгуулах нь зүйтэй байна.

Бэлтгэгдсэн тоног төхөөрөмж бүрэн ашиглагдахгүй байна

1.29 Сангийн сайд, ЭМС-ын 2006 оны 380/367 дугаар тушаалаар 2006 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хийсэн зохицуулалтаар Гэмтэл согог, судлалын үндэсний төвд 40,0 сая төгрөгийн рентген аппарат авахаар шийдвэрлэжээ. ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 45.2.3-т "... агентлаг, байгууллага ... 20-50 сая хүртэл төгрөгийн өртөг бүхий бараа, үйлчилгээний захиалагч байна" гэж заасны дагуу Гэмтэл согог, судлалын үндэсний төв тендер шалгаруулалтыг зохион байгуулах ёстой атал ЭМЯ эрхийг өөртөө авч, Булгат овоо ХХК-тай шууд гэрээ байгуулжээ.

1.30 2006 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Булгат овоо ХХК-иас Клиникийн 2 дугаар эмнэлэгт 69,8 сая төгрөгийн үнэтэй компьютер томографын аппарат, Гэмтэл согогийн эмнэлэгт 40,0 сая төгрөгийн үнэтэй рентген аппарат тус тус нийлүүлсэн боловч компьютер томографын аппарат суурилуулаад 7 хонолгүй эвдэрсэн, рентген аппаратыг одоо болтол угсраагүй байна. Эдгээр аппаратууд ажиллаж байсан бол оношлогооны чанар дээшилж, олон нийт чирэгдэл багатай үйлчлүүлэх боломжтой байжээ.

1.31 Улсын клиникийн нэгдсэн эмнэлэгт суурилуулсан Эм Эр Аи аппаратын үйлчилгээний төлбөрийн жишиг үнэ батлагдаагүй гэсэн шалтгаанаар үйлчилгээ явуулж эхлээгүй байхад баталгаат хугацаанаас нь 120 хоног хэтэрчээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж худалдан авах ажиллагаанд захиалагч ЭМЯ болон СЯ хариуцлагагүй хандаж нийлүүлсэн тоног төхөөрөмж, барилга их засварын гүйцэтгэл, үр дүнд хяналт тавихгүй байна.



Их засвар, тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаагүй байна

1.32 2006 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Арьсны өвчин судлалын төвд 38,0 сая төгрөг, Эх нялхасын эрдэм шинжилгээний төвд 80,8 сая төгрөг, Халдварт өвчин судлалын үндэсний төвд 65,0 сая төгрөг, төвлөрсөн арга хэмжээний хөрөнгөөр хийгдсэн 99,1 сая төгрөг, нийт 282,9 сая төгрөгийн их

засварын хөрөнгийг барилга байгууламжийн өртгийг нэмэгдүүлж, нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.

1.33 ЭМС-ын 2007 оны 3 дугаар тушаалаар хуваарилсан эхо аппаратын марк, үнийн дүнг тушаалд тодорхой зааж өгөөгүйгээс НББ-д бүрэн тусгаагүй бөгөөд зөөврийн эхо аппаратыг хүлээн авсан эсэхийг аймгийн Аудитын газрууд болон клиник эмнэлгүүдээс тодруулахад Сүхбаатар аймгийн нэгдсэн болон сумын эмнэлэгт 6, Баянхонгорт 4, Булганд 1, Хөвсгөлд 1, Увсад 1, Хэнтийд 1 эхо аппарат эзэндээ очоогүй байна.

1.34 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн тоног төхөөрөмжийг ЭМС-ын тушаалд заагдсаны дагуу олгож байгаа эсэхэд хяналт тавиагүйгээс зарим сумын эмнэлгүүдэд хуваарьт хөрөнгийг сольж олгосны зэрэгцээ “Монмэс”, “Эдэльвайз” хувийн эмнэлэг, Баянзүрх дүүргийн “Эмнэхүй”, Хөвсгөл аймгийн “Эрчим”, “Буян” зэрэг 5 өрхийн эмнэлэгт зөөврийн эхо аппаратыг үнэгүй тараажээ.

1.35 Монгол Улсад Тайванийн Тайпей хотын даргын бэлэглэсэн түргэн тусламжийн 10 автомашиныг тээвэрлэн авчрах зардлын зориулалтаар ЭМС-ын 2006 оны 240 дүгээр тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагуудын 2005 оны дансны үлдэгдэлд төвлөрүүлсэн хөрөнгөөс 20,3 сая төгрөгийг “Хүний хөгжлийн сан” ТББ-ын дансанд шилжүүлжээ. Гэтэл буцалтгүй тусламжийн дээрх автомашиныг “Хүний хөгжлийн сан” ТББ өнөөг хүртэл ЭМЯ-нд хүлээлгэн өгөөгүй, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй тул 20,3 сая төгрөгийг буцаан төлүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Засварын ажил хийгдээгүй байна

1.36 Ривер саунд баар, Эргэн дурсахуй клубт түрээслүүлж буй ЭМЯ-ны байрыг эрүүл мэндийн үйлчилгээний болон иргэдийн эрүүл мэндийг дэмжих төвийн зориулалтаар засаж, тохижуулахад төвлөрсөн арга хэмжээний хөрөнгөөс 97,0 сая төгрөгийг зарцуулахаар ЭМС-ын 2006 оны 402 дугаар тушаалаар шийдвэрлэжээ.

1.37 ТБОНӨХБАУХА тухай хуулиар 50,0 сая төгрөг хүртэл төсөвт өртөгтэй ажлыг харьцуулалтын аргаар худалдан авах ёстой. Гэтэл Мөнгөн сарьдаг ХХК-тай 49,0 сая төгрөгийн, Далай буян ХХК-тай 48,0 сая төгрөгийн шууд гэрээ байгуулж нийт 72,0 сая төгрөгийг компаниудын данс руу шилжүүлжээ.

1.38 Гэрээнд засварын ажлыг 2006 оны 12 дугаар сарын 25-наас 2007 оны 3 дугаар сарын 15-ны хооронд хийж, ашиглалтад оруулахаар заасан боловч одоо хүртэл ямар ч ажил хийгдээгүй, ЭМЯ хуучин түрээслэгч байгууллагуудтай хийсэн гэрээний хугацааг сунгасан тул дээрх компаниудад шилжүүлсэн 72,0 сая төгрөгийг буцааж авах нь зүйтэй байна.

ЗӨВЛӨМЖ

Эрүүл мэндийн сайд Д.Туяад:

- Эрүүл мэндийн салбарын мастер төлөвлөгөө, зээл, тусламжийн нийлүүлэлттэй уялдуулсан ирэх 5 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулж мөрдүүлэх
- Бэлтгэсэн тоног төхөөрөмжийн зарцуулалт, бүртгэлд тавих хяналтыг сайжруулж, үр өгөөжийг дээшлүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах
- Хувийн байгууллагад олгосон зөөврийн эхо аппаратын үнийг нөхөн төлүүлэх

Бүлэг 2

Төслүүдийн нягтлан бодох бүртгэлийг сайжруулах шаардлагатай байна

2.1 2001 онд НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулган дээр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Аннан жил бүр 6 сая гаруй хүний амь насанд хүрч байгаа ДОХ, сүрьеэ, хумхаа өвчинтэй тэмцэх санхүүжилтийн шинэ механизм бүрдүүлж, эдгээр өвчний эсрэг өргөн цар хүрээтэй хөтөлбөр хэрэгжүүлэх санаачилга гаргасны дагуу 2002 онд Глобаль сан байгуулагджээ.

2.2 Глобаль сан нь жил бүр төслийн уралдаан зарладаг бөгөөд манай улс үүнд идэвхтэй оролцож “ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх үндэсний хөтөлбөрийг бэхжүүлэх”, “Сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх”, “Олон эмийн дасалтай сүрьеэтэй тэмцэх”, “Зорилтот бүлэгт чиглэсэн ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг өргөжүүлэх” дөрвөн төслийг ЭМЯ, Глобаль сангийн хооронд байгуулсан тусламжийн гэрээний дагуу хэрэгжүүлж байна.

2.3 Үндсэн хүлээн авагч ЭМЯ төслүүдийн үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангах Глобаль сангийн Хөтөлбөр зохицуулах нэгж /ХЗН/-ийг байгуулж, ХЗН төслийн зохицуулагч, ДОХ-ын мэргэжилтэн, сүрьеэгийн мэргэжилтэн, санхүүгийн ажилтан зэрэг 14 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

2.4 Глобаль сан төслийн хэрэгжилтийг хангахад оролцогч талуудын эрх тэгш оролцоог хангах, үйл ажиллагааг хооронд нь уялдуулан зохицуулах, төслийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх үүрэг бүхий ОНЗЗ ажиллуулах шаардлагыг төсөл хэрэгжүүлэгч орнуудад тавьдаг байна.

2.5 Глобаль сан НҮБ-ын хөтөлбөрийн төслийн үйлчилгээний газар (UNOPS) манай улсад өөрийн төлөөлөл болгон ажиллуулдаг бөгөөд тус газар нь төслүүдийн хэрэгжилтийг хөндлөнгөөс хянаж, үйл ажиллагааны болон санхүүгийн мэдээ тайланг баталгаажуулж, үнэлгээ өгч дараагийн санхүүжилтийг хийх эсэх талаар Глобаль санд заавар өгч байна.

ОНЗЗ төслүүдийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх үүргээ бүрэн биелүүлээгүй байна

2.6 Монгол Улс Глобаль сангийн шаардлагад нийцүүлэн ОНЗЗ-ийг “ХДХВ/ДОХ-ын мэргэжлийн зөвлөл”-ийг түшиглэн 2002 онд байгуулжээ. ОНЗЗ-ийн бүрэлдэхүүн байгуулагдсанаасаа хойш 3 удаа өөрчлөгдөөд байна.

2.7 ОНЗЗ санхүүгийн үндсэн болон салбар хүлээн авагчийг сонгох, төслүүдийн ажлын төлөвлөгөө, хяналт шинжилгээ, үнэлгээ, ханган нийлүүлэлтийн төлөвлөгөө болон түүнд орох өөрчлөлтүүдийг батлах зэрэг ажлыг гүйцэтгэж байна.

2.8 ОНЗЗ 2002-2006 онд улирал тутам буюу нийт 20 удаа хуралдаж байжээ. Хурлын протоколуудаас үзвэл ДОХ, сүрьеэгийн чиглэлээр мэргэжлийн салбар зөвлөл байгуулсан боловч үйл ажиллагаа нь тогтмолжоогүй, ОНЗЗ-ийн гишүүдийн идэвхи сул, үүргээ сайн ойлгоогүй, үндсэн хүлээн авагч ЭМЯ-тай хамтран ажиллах талаар дутмаг, төслүүдийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

2.9 Дээрх байдлаас шалтгаалан 2007 оны 1 дүгээр сарын 18-ны хурлаар тус зөвлөлийн бүтцийг шинэчлэх шийдвэр гаргаж одоогийн ОНЗЗ-ийг байгуулжээ. Цаашид ОНЗЗ-ийн чадавхийг бэхжүүлэх, үйл ажиллагааг нь ЭМЯ-тай уялдуулах шаардлагатай байна.

Төслийн 2006 оны үйл ажиллагаа саатжээ

2.10 Манай улсад хэрэгжиж буй 4 төслөөс аудитад хамрагдсан “Монгол Улсад сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх”, “Олон эмэнд дасалтай сүрьеэтэй тэмцэх”, “ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх үндэсний хөтөлбөрийг бэхжүүлэх” төслүүд 2003-2006 онд нийт 4770,1 мянган ам.долларын санхүүжилт авч, төслийг хэрэгжүүлэгчээр ХӨСҮТ, Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв, Цусны төв, Боловсролын хүрээлэн болон ДОХ-той тэмцэх үндэсний сан, МСТН, Дэлхийн зөн зэрэг 15 төрийн болон ТББ хамтран ажилласан байна.

2.11 Сүрьеэтэй тэмцэх 2 төсөл Улаанбаатар хот, 21 аймгийг хамруулан сүрьеэгийн ДОТС-ын бодлогыг хэрэгжүүлэх, оношлогооны чадавхийг сайжруулах ажлуудыг шинэ шатанд гаргаж, улсын хэмжээнд сүрьеэгийн илрүүлэлт 57 хувь байсныг 82 хувьд, эдгэрэлт болон эмчилгээ дуусгасан үзүүлэлт 86.7 хувь байсныг 88 хувьд хүргэж, төлөвлөсөн ажлуудыг 100-113 хувиар биелүүлжээ. Эмэнд дасалтай сүрьеэгийн оношлогоо, эмчилгээ анх удаа хийгддэг болсноос гадна улсын хэмжээнд сүрьеэгийн эмээр хангаж байна.

2.12 ХДХВ/ДОХ-ын төсөл мэргэжлийн сургалт явуулах, БЗДХ-ын оношлогоо, эмчилгээг сайжруулах, цусны аюулгүй байдлыг хангах, эм урвалж, тоног төхөөрөмж, бэлгэвч нийлүүлэх зорилтын хүрээнд төлөвлөсөн ажлуудыг 100-150 хувиар биелүүлжээ. Төслийн үр дүнд жирэмсэн эмэгтэйчүүд, цусны доноруудын дунд тэмбүүгийн тархалт 4.6 хувиас 2.2 хувь, Дархан-Уул аймагт 100 хувь бэлгэвч хөтөлбөрийг хэрэгжүүлснээр бэлгэвчийн хэрэглээ нэмэгдэж, тэмбүүгийн тархалт 18 хувиас 3.5 хувь болон буурсан байна.

2.13 2003 оноос 5 жилийн хугацаатай хэрэгжиж эхэлсэн ДОХ, сүрьеэгийн төслүүдийн хэрэгжилтийг Глобаль сан хангалттай гэж үзэн, 2008 оноос эхлэн тус бүр 6 жилээр сунгахаар болжээ.

2.14 ЭМС асан Л.Гүндалай 2006 оны эцсээр 296, 314, 408 дугаар тушаал гаргаж, ХЗН-ийн бүх ажилтныг үүрэгт ажлаас чөлөөлснөөс Глобаль сан ЭМЯ-ыг төслүүдийн үйл ажиллагааны хэвийн хэрэгжилтийг хангах чадваргүй гэж үзэн 746575,14 ам.долларын санхүүжилтийг 2006 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс зогсоожээ.

Төслийн нэр	Саатсан санхүүжилт
“Монгол Улсад сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх нь”	102.681,49 ам.доллар
“ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх үндэсний хөтөлбөрийг бэхжүүлэх”	271.449,92 ам.доллар
“Олон эмийн дасалтай сүрьеэтэй тэмцэх”	372.443,73 ам.доллар

2.15 Энэ хугацаанд “Зорилтот бүлэгт чиглэсэн ХДХВ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг өргөжүүлэх” төслийн 2006 оны 7 дугаар сард орсон санхүүжилтээс дээрх төслүүдийн үйл ажиллагааны зохих зардлыг санхүүжүүлсэн байна. Сүрьеэтэй тэмцэх төсөл сүрьеэгийн хоолтой болон гэрээр эм харж уулгах эмчилгээг 2006 оны 12 дугаар сар хүртэл харилцагч байгууллагуудаас зээлээр хэрэгжүүлж, үүнээс хойш тасалдахад хүрчээ.

2.16 Глобаль сан ЭМЯ-нд тодорхой үүрэг даалгавар өгч, биелэлтийг харгалзан 2007 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөс санхүүжилт хийж эхэлсэн байна.

Бүртгэлийн бодлого боловсруулах шаардлагатай байна

2.17 ХЗН төслийн батлагдсан ажлын болон ханган нийлүүлэлт, хяналт шинжилгээ үнэлгээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, салбар хүлээн авагчдын хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх, ОНЗЗ-ийг мэдээллээр хангах үүргийг гүйцэтгэж байна.

2.18 Глобаль сан үр дүнд тулгуурласан санхүүжилтийг хагас жилээр олгодог бөгөөд ХЗН салбар хүлээн авагчдын тайланг нэгтгэн гэрээнд заасан хугацаанд төслийн санхүүгийн улирал, жилийн тайланг санхүүжүүлэгч байгууллагын гаргасан маягтын дагуу бэлтгэн тайлагнаж байна.

2.19 Глобаль сангаас ЭМЯ-тай байгуулсан тусламжийн гэрээний 7 дугаар бүлэгт “Үндсэн хүлээн авагч нь тухайн улс оронд хүлээн зөвшөөрөгдсөн НББ-ийн нийтлэг стандартын дагуу данс бүртгэлийг хөтлөх буюу Глобаль сан болон үндсэн хүлээн авагчийн хооронд урьдчилан бичгээр тохирсон НББ-ийн бусад стандартын дагуу хөтөлнө” гэж заасан.

2.20 Гэтэл Монгол Улсад мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн төслийн үйл ажиллагааны онцлогт тохирсон бүртгэлийн бодлого боловсруулж, мөрдөөгүй байна. Үүний улмаас санхүүгийн үйл ажиллагаа, НББ хөтлөлтөд дараахь зөрчил гарчээ:

- Тусламжийн гэрээний дагуу ХЗН 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон санхүүгийн тайланг жил бүр бэлтгэж, аудит хийлгэж ирсэн боловч 2003-2006 оны санхүүгийн тайлан удирдлагын гарын үсгээр баталгаажгаагүй байна.
- Төслийн санхүүгийн баримтад гарын үсэг зурах эрх 2006 оноос хойш 5 удаа өөрчлөгдсөн нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын жигд ажиллагааг алдагдуулж, төслийн үйл ажиллагааг хэвийн явуулахад саад учруулжээ.
- ХДХВ/ДОХ-ын төслийн анхан шатны бүртгэл хөтлөлт, дансны харьцааны бичилтийг буруу хийж авлагыг өглөгөөр бүртгэсний улмаас 2006 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан 12644,49 ам.долларын алдаатай илэрхийлэгджээ. Өглөг зөвхөн 2006 онд бус өмнөх оноос дамжин ирсэн байна.
- ХДХВ/ДОХ-ын төслийн мэдээлэл, сургалт сурталчилгааны дэд хөтөлбөрийн хүрээнд 2004-2006 онд ширээний календарь, бал зэрэг зар сурталчилгааны материал хийлгэжээ. Гэтэл эдгээр материалын зарцуулалтад бараа материалын нэгдсэн бүртгэл хөтлөөгүй байна.

➤ Сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх төслийн хүрээнд МСТН-ийн ажлын хэрэгцээнд автомашин худалдан авах тендерийг ЭМЯ-ны тендерийн хороо шалгаруулж, Глобал инвест ХХК 11200 ам.долларын Хьюндай старекс маркийн машин нийлүүлэх гэрээ байгуулжээ. Тендерийн үнэлгээний хорооны хуралдааны тэмдэглэлд “шинэ” гэж заасан боловч тус компани иргэн Хосбаярын нэр дээр байсан, хуучин автомашиныг нийлүүлснээс дугуй шинээр тавих, резин солих зэрэг засвар үйлчилгээнд 800 ам.доллар зарцуулжээ. Машины үнэ 11200 ам.долларыг бэлнээр төлсөн байна.

2.21 ЭМЯ-наас төслийн НББ, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас дээрх зөрчлүүд гарсан гэж үзлээ. Цаашид дотоод хяналт, үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгож хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Эрүүл мэндийн сайд Д.Туяад:

- Төслийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг улам сайжруулж, төслийн онцлогт тохирсон НББ-ийн бодлого боловсруулж, мөрдүүлэх

Холбогдох байгууллагын санал

Эрүүл мэндийн яамны санал


**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ**
210648 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын VIII байр,
Утас/Факс: 26-36-85, E-mail: moh@moh.mn,
http://www.moh.mn

2007.06.27 № 3/1624
танай _____-ны № _____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, Глобаль сангийн дэмжлэгтэй хэрэгжиж байгаа ДОХ, сурьвээгийн төслүүдийн үйл ажиллагаанд аудит хийгээд ирүүлсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилган холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллах болно.


ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА
Б.БАТСЭРЭЭДЭНЭ

08 2558



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ОРЛОГЧ Б.БАТБАЯР ТАНАА

Санал өгөх тухай

Улсын Их Хурлын санал, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2007 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслүүдийн хэрэгжилт, үр дүнд Танай байгууллагаас хийж ирүүлсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн 2.20-д танай илрүүлсэн зөрчлүүдэд дараах тайлбар, саналыг тавьж байна. Үүнд:

1. Тусламжийн гэрээний дагуу ХЗН 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон санхүүгийн тайланг жил бүр бэлтгэж, аудит хийлгэж ирсэн боловч 2003-2006 оны санхүүгийн тайлан удирдлагын гарын үсгээр баталгаажуулж байна гэжээ.

Хөтөлбөр зохицуулах нэгж (ХЗН) нь Глобал сангаас тавьсан шаардлага, маягтын дагуу үйл ажиллагааны болон тэтгэмжийн хөрөнгийн зарцуулалтын тайланг улирал, хагас жил, жилээр гаргаж төслийн удирдагч буюу ЭМ-ийн дэд сайдын гарын үсгээр баталгаажуулсаны дараа төслийн хөндлөнгийн хянагч байгууллага болох "НҮБ-ын хөтөлбөрийн төслийн үйлчилгээний газар(UNOPS)"-аар хянуулан дахин баталгаажуулж Глобал санд илгээдэг.

2003-2006 оны хооронд "Монгол улсад Сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх нь" төслийн хүрээнд 12, "ХДХВ/ДОХ/БЗДХ-аас урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх үндэсний хөтөлбөрийг бэхжүүлэх нь" төслийн хүрээнд 11, "Олон эмэнд дасалтай сүрьеэтэй тэмцэх нь" төслийн хүрээнд 4 удаа үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг гаргасан байна. Тайлан тус бүр ЭМ-ийн дэд сайд буюу Төслийн удирдагчийн гарын үсгээр баталгааждаг.

Үүнээс гадна Глобал сан, ЭМЯ-ны хооронд хийгдсэн гэрээ ёсоор ЭМЯ нь жил бүр "Хараат бус аудит"-ийн компанийг сонгож төслүүдийн санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийлгэдэг. ХЗН нь аудит хийлгэх санхүүгийн тайланг гаргаж, төслийн зохицуулагч нарын гарын үсгээр баталгаажуулдаг (Хавсралт 1, Гурван төслийн Глобал санд явуулдаг хагас жилийн тайлан, Гурван төслийн 2004-2006 оны санхүүгийн тайлан мэдээ).

Иймд "...санхүүгийн тайлан удирдлагын гарын үсгээр баталгаажуулж" гэсэн дүгнэлтийг тайлангаас хасч өгнө үү.

Тайлбар 1-ийг үзнэ
үү

Тайлбар 2-ыг
үзнэ үү.

2. Төслийн санхүүгийн баримтанд гарын үсэг зурах эрх 2006 оноос хойш 5 удаа өөрчлөгдсөн нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сулруулжээ гэжээ.

Үүнийг "2006 оны 9 дүгээр сараас хойш 7 сарын дотор 5 удаа өөрчлөгдсөн" гэж тодруулж өгнө үү. Энэ нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сулруулсан бус төслийн үйл ажиллагааг хэвийн, тогтвортой явуулахад саад учруулж төслүүдийн санхүүжилт зогсох, үйл ажиллагаа бүтэн улирлаар хойшлогдох зэрэг асуудалд хүргэсэн юм.

3. ХДХВ/ДОХ-ын төслийн анхан шатны бүртгэл хөтлөлт, дансны харьцааны бичилтийг буруу хийж авлагыг өглөгөөр бүртгэсний улмаас 2006 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан 12644.49 ам. долларын алдаатай илэрхийлэгджээ. Өглөг зөвхөн 2006 онд бус өмнөх оноос дамжин ирсэн байна гэжээ.

Одоо төслүүдийн үйл ажиллагаанд "Хараат бус санхүүгийн аудит" хийгдэж байгаа бөгөөд үүгээр алдаатай илэрхийлэгдсэн 12644.49 ам. долларын дансны бичилтийг залруулах болно.

4. ХДХВ/ДОХ-ын төслийн мэдээлэл, сургалт сурталчилгааны дэд хөтөлбөрийн хүрээнд 2004-2006 онд "Ди Ди Си" ХХК-иар 65,7 сая төгрөгийн ширээний календарь, бал зэрэг сурталчилгааны материал хийлгэжээ. Гэтэл эдгээр материалыг орлогод авч, зарцуулалтад бараа материалын бүртгэл хөтлөөгүй байна гэжээ.

Төслийн мэдээлэл, сургалт сурталчилгаа(МСС)-ны дэд хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн сурталчилгааны материалыг ХЗН тухайн ажлыг гүйцэтгэсэн компаниас зарлагын падаанаар хүлээн авч зарцуулалтанд хяналт тавьж бүртгэл хөтөлдөг. Тухайлбал: 1. Эрүүл мэндийн хөгжлийн үндэсний төв(ЭМХҮТ)-өөр дамжуулан нийслэл, аймаг, сум, дүүргүүдэд түгээсэн МСС-ны материалын зарцуулалтын бүртгэл хөтөлдөг (Хавсралт 2. Монгол шуудан компаниар дамжуулан түгээсэн МСС-ны материалын бүртгэл 3ш),

2. МСС-ны материал ХЗН-ээр дамжин түгээгдсэн тохиолдолд материал хүлээн авсан байгууллага, хүний гарын үсгийг зуруулан хүлээлгэж өгдөг бөгөөд үүн дээрээ үндэслэн зарцуулалтын нэгдсэн товчоог гаргадаг(Хавсралт 3. ХЗН-ээр дамжуулан түгээсэн МСС-ны материалын бүртгэл 2ш).

Иймд "...МСС-ны материалын зарцуулалтанд бараа материалын бүртгэл хөтлөөгүй" гэсэн дүгнэлтийг тайлангаас хасч өгнө үү.

5. Сүрьеэтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх төслийн хүрээнд МСТН-ийн ажлын хэрэгцээнд автомашин худалдан авах тендерийг ЭМЯ-ны тендерийн хороо шалгаруулж, Глобал инвест ХХК 11200 ам.долларын Хьюндай старекс маркийн шинэ автомашин нийлүүлэх гэрээ байгуулжээ. Тендерийн баримт бичигт шинэ гэж заасан боловч тус компани иргэн Хосбаярын нэр дээр байсан хуучин автомашиныг нийлүүлснээс дугуй шинээр тавих, резин солих зэрэг засвар үйлчилгээнд 800 ам.доллар зарцуулжээ. Машины үнэ 11200 ам.долларыг бэлнээр төлсөн байна гэжээ.

Тайлбар 3-ыг
үзнэ үү

Тайлбар 4-ийг үзнэ үү

ЭМЯ-ны тендерийн хороо нь тендерт ирүүлсэн материалуудаас сонгон шалгаруулалт хийж "Глобал инвест" ХХК-иас Хьюндай старекс маркийн автомашиныг 11,200 ам. доллараар худалдан авах гэрээг хийсэн. Ийм маркийн автомашин нь үйлдвэрээсээ 30,000-40,000 ам. долларын үнэтэйгээр нийлүүлэгддэг тул бидний төлөвлөсөн үнэнд цоо шинэ машин авах боломжгүй юм. Гэрээнд "шинэ" машин авна гэсэн үг тусгагдаагүй болно. Иргэн Д. Хосбаяр нь Глобал инвест ХХК-ний гадаад харилцааны менежер бөгөөд тус компанийг төлөөлж байсан болно (Хавсралт 4. Автомашин нийлүүлэх гэрээ, Иргэн Д. Хосбаярын тодорхойлолт, Шинэ Хьюндай старекс маркийн автомашины үнийн жишиг).

Иймд дүгнэлтийн "... Глобал инвест ХХК 11200 ам.долларын Хьюндай старекс маркийн шинэ автомашин нийлүүлэх гэрээ байгуулжээ" гэсэн хэсгийн "шинэ" гэсэн үгийг хасах. Мөн "Тендерийн баримт бичигт шинэ гэж заасан боловч тус компани иргэн Хосбаярын нэр дээр байсан хуучин автомашиныг нийлүүлснээс дугуй шинээр тавих, резин солих зэрэг засвар үйлчилгээнд 800 ам.доллар зарцуулжээ" гэсэн хэсгийг хасч өгнө үү.

Та бүхнийг бидний ажлыг ойлгож дэмжлэг үзүүлнэ гэдэгт итгэж байна.

Хувийг: Монгол улсын их хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд Д. Туяад

Төслийн зохицуулагч



А. Оюунбилэг

Үндэсний аудитын газрын тайлбар

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.2-т заасныг үндэслэн дараахь тайлбарыг өгч байна. Үүнд:

Тайлбар 1

Глобаль сангийн дэмжлэгтэй хэрэгжиж буй төслүүдийн санхүүгийн үйл ажиллагааны тайланг тайлагналын шатанд үндсэн хүлээн авагчаар тухай бүр нь хянуулан гарын үсгээр баталгаажуулаагүй байсныг аудитын тайланд тусгасан бөгөөд ХЗН-ээс ирүүлсэн саналыг хүлээн авах боломжгүй байна.

Тайлбар 2

Саналыг хүлээн авч тайланд тусгав.

Тайлбар 3

Сурталчилгааны материалыг тарааж байсан арга хэмжээ бүрт түгээсэн материалын зарцуулалтын тайлан байгаа боловч бараа материалын нэгдсэн тайланг хөтөлж, тайлагнаагүй байсан. Энэ нь бараа материалд тавих дотоод хяналтыг бууруулж байна гэж аудитын баг үзсэн юм.

Тайлбар 4

Тендерийн үнэлгээний хорооны 2004 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд шинэ автомашин авах талаар дурдагдсан байгаа тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн Зөөврийн Эхо аппаратыг
хуваарилсан, олгосон, хүлээн авсан эсэхийг аудитын явцад тодруулсан
байдал**

(2007 оны 5 дугаар сарын 5-ны байдлаар)

№	Аймаг, сумын нэр	Тушаалаар олговол зохих	ЭМЯ-наас олгосон	Хүлээн авсан эсэх	Тайлбар
Архангай					
1	Их тамир	1	1	авсан	
2	Хотонт	1	1	авсан	
3	Цэнхэр	1	1	авсан	
4	Хангай	1			
5	Жаргалант	1			
6	Цэцэрлэг	1			
7	Цахир	1			
8	Аймгийн нэгдсэн эмнэлэг	2	2	авсан	
Баян-Өлгий					
1	Булган	1			
2	Сагсай	1			
3	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1			
Сүхбаатар					
1	Баяндэлгэр	1	1	аваагүй	
2	Мөнххаан	1	1	аваагүй	
3	Түвшинширээ	1	1	аваагүй	
4	Аймгийн нэгдсэн эмнэлэг	2	2	аваагүй	
5	Уулбаян сумын эмнэлэг		1	аваагүй	тушаалд заагдаагүй
Увс					
1	Наранбулаг	1			
2	Өмнөговь	1	1	аваагүй	
3	Тариалан	1			
4	Бөхмөрөн	1			
5	Завхан	1			
6	Малчин	1			
7	Зүүнхангай	1			
8	Өндөрхангай	1			
9	Цагаанхайрхан	1			
10	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1			
Ховд					
1	Манхан	1			
2	Үенч	1	1	авсан	
3	Ховд	1			
4	Алтай	1			
5	Дарви	1			
6	Цэцэг	1			
Дархан Уул					
1	Хонгор	1			

№	Аймаг, сумын нэр	Тушаалаар олговол зохих	ЭМЯ-наас олгосон	Хүлээн авсан эсэх	Тайлбар
2	Шарын гол сум	1			
3	Аймгийн нэгдсэн эмнэлэг	2			
	Баянхонгор				
1	Баянлиг	1	1	аваагүй	
2	Баянговь	1			
3	Шинэжинст	1			
4	Баян-Өндөр	1	1	аваагүй	
5	Хүрээ марал	1			
6	Баянбулаг	1			
7	Гурванбулаг	1			
8	Заг	1			
9	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1			
10	Баацагаан		1	аваагүй	тушаалгүй
11	Баянцагаан		1	аваагүй	тушаалгүй
12	Богд				
	Булган				
1	Тэшиг	1			
2	Рашаант	1			
3	Хутаг-Өндөр	1	1	авсан	
4	Аймгийн нэгдсэн эмнэлэг		1	аваагүй	
	Говь-Алтай				
1	Бугат	1	1	авсан	
2	Тонхил	1	1	авсан	
3	Цогт	1			
4	Цээл	1			
5	Чандмань	1			
6	Эрдэнэ	1			
	Дорноговь				
1	Хөвсгөл	1			
2	Айраг	1	1	авсан	
3	Хатанбулаг	1	1	авсан	
	Дорнод				
1	Баяндун	1			
2	Матад	1			
3	Чулуун хороот	1			
4	Эрэн	1			
5	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1			
	Дундговь				
1	Өндөршил	1			
2	Сайхан овоо	1	1	авсан	
3	Аймгийн нэгдсэн эмнэлэг	3	3	авсан	
4	Говь-Угтаал	1	1	авсан	
	Завхан				
1	Асгат	1			
2	Баянтэс	1			
3	Баянхайрхан	1			
4	Сантмаргац	1			
5	Тэс	1	1	авсан	

№	Аймаг, сумын нэр	Тушаалаар олговол зохих	ЭМЯ-наас олгосон	Хүлээн авсан эсэх	Тайлбар
6	Ургамал	1			
7	Цэцэн Уул	1	1	авсан	
8	Шилүүстэй	1	1	авсан	
9	Тосонцэнгэл	1	1	авсан	
10	Аймгийн нэгдсэн эмнэлэг	2	1	авсан	
11	Эрдэнэхайрхан		1	авсан	тушаалд заагдаагүй
12	Дөрвөлжин		1	авсан	тушаалд заагдаагүй
13	Түдэвтэй		1	авсан	тушаалд заагдаагүй
14	Сонгино		1	авсан	тушаалд заагдаагүй
15	Мандал		1	авсан	тушаалд заагдаагүй
Өвөрхангай					
1	Баруун баян улаан	1			
Өмнөговь					
1	Сэврэй	1	1	авсан	
2	Аймгийн нэгдсэн эмнэлэг	2	2	авсан	
Сэлэнгэ					
1	Орхонтуул	1			
2	Хүдэр	1			
3	Сайхан хөтөл	1			
4	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1			
Хэнтий					
1	Батширээт	1			
2	Дадал	1	1	авсан	
3	Норовлин	1			
4	Аймгийн нэгдсэн эмнэлэг	2	2	1-ийг авсан	аваагүй 1
Орхон					
1	Аймгийн нэгдсэн эмнэлэг	3	3	авсан	
Говьсүмбэр					
1	Аймгийн нэгдсэн эмнэлэг	3	2	авсан	
Говь-Алтай					
1	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1	1	авсан	
2	Бигэр	1	1	авсан	
3	Төгрөг	1	1	авсан	
Өвөрхангай					
1	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1	1	авсан	
2	Бат-Өлзий	1	1	авсан	
3	Богд	1	1	авсан	
4	Уянга	1	1	авсан	
Төв					
1	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1	1	авсан	
2	Батсүмбэр	1	1	авсан	
3	Жаргалант	1	1	авсан	
4	Заамар	1	1	авсан	
5	Эрдэнэсант	1	1	авсан	
Хөвсгөл					
1	Аймгийн нэгдсэн эмнэлэг	1	1	авсан	аваагүй 1

№	Аймаг, сумын нэр	Тушаалаар олговол зохих	ЭМЯ-наас олгосон	Хүлээн авсан эсэх	Тайлбар
2	Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газар	2			
3	Мөрөн өрхийн эмнэлэг	2			
4	Эрчим өрхийн эмнэлэг	1	1	авсан	
5	Буян өрхийн эмнэлэг	1	1	авсан	
6	Тулга өрхийн эмнэлэг	1	1	авсан	
7	Энэрэл өрхийн эмнэлэг	1	1	авсан	
8	Дэлгэрмөрөн өрхийн эмнэлэг	1	1	авсан	
9	Алаг-Эрдэнэ	1	1	авсан	
10	Арбулаг	1	1	авсан	
11	Баянзүрх	1	1	авсан	
12	Бүрэнтогтох	1	1	авсан	
13	Галт	1	1	авсан	
14	Жаргалант	1	1	авсан	
15	Их Уул	1	1	авсан	
16	Рашаант	1	1	авсан	
17	Рэнчинлхүмбэ	1	1	авсан	
18	Тосонцэнгэл	1	1	авсан	
19	Төмөрбулаг	1	1	авсан	
20	Түнэл	1	1	авсан	
21	Улаан уул	1	1	авсан	
22	Цагааннуур	1	1	авсан	
23	Цагаан Уул	1	1	авсан	
24	Цагаан Үүр	1	1	авсан	
25	Цэцэрлэг	1	1	авсан	
26	Чандмань өндөр	1	1	авсан	
27	Шинэ Идэр	1	1	авсан	
28	Тариалан	1	1	авсан	
29	Хатгал	1	1	авсан	
30	Ханх		1		тушаалгүй олгосон
31	Эрдэнэбулган		1		тушаалгүй олгосон
32	"Эдэльвайс" хувийн эмнэлэг		1		тушаалгүй олгосон
	Бусад				
1	Эх нялхасын эрдэм шинжилгээний төв	4	4	авсан	
2	"Монмэс" хувийн эмнэлэг		1		тушаалгүй олгосон
3	Хавдар судлалын төв	4	4	авсан	
4	Клиникийн төв эмнэлэг	2	2	авсан	
5	Баянзүрх "Эмнэхүй" ББН өрхийн эмнэлэг		1		тушаалгүй олгосон
6	Клиникийн 3 дугаар эмнэлэг	3	3	авсан	
7	Клиникийн 2 дугаар эмнэлэг	1			
8	Нийслэлийн эрүүл мэндийн газар	34	35	авсан	тушаалгүй олгосон
9	Багануур дүүрэг	2	2	авсан	
10	Налайх дүүрэг	2	2	авсан	
	Бүгд	194	145		

Тушаалд заагдаагүй 14
 Хүлээн аваагүй 14
 Тушаалд заагдсан сумын эмнэлэг 109

№	Аймаг, сумын нэр	Тушаалаар олговол зохих	ЭМЯ-наас олгосон	Хүлээн авсан эсэх	Тайлбар
---	------------------	-------------------------	------------------	-------------------	---------

Эхо аппаратын үлдэгдэл

105